

# Үйлдвэрлэлийн зориулалттай АББ-ын давтамж хувиргагчууд ACS880-07 серийн 45 ~ 2800 кВт чадал бүхий удирдлагын хайрцагтай дан давтамж хувиргагчууд



ACS880-07 нь АББ-ын шинэ төрлийн олон талын ажиллагаа бүхий давтамж хувиргагчуудын нэг юм. Эдгээр давтамж хувиргагчууд нь бүх төрлийн хувьсах гүйдлийн хөдөлгүүр, автомат системүүдэд тохиромжтой ба хэрэглэгчдийн болон бизнесийн шаардлагуудыг хангахуйц юм.



**Бүхий л төрлийн хэрэглээнд зохицож ажиллах боломжтой шинэ дэвшилтэт технологийн ард ашиглахад хялбар, бүтээжийг нэмэгдүүлж, эрчим хүчийг хэмнэлттэй ашиглахаар зохион бүтээгдсэн АББ-ын давтамж хувиргагч оршдог**

**Боломжийг хязгаарлахгүйгээр ажиллагааг хялбарчлах:**

Удирдлагын хайрцагтай ACS880-07 биеэ даасан давтамж хувиргагчийг янз бүрийн үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах боломжтой юм. Ялангуяа туузан дамжуурга, хатаах зуух, шахагч, насос, сэнс зэрэгт нэн тохиромжтой. Энэ давтамж хувиргагч нь шулуутгагч, DC холбогч, хувиргагч болон авсаархан удирдлагын хайрцаг зэргээс бүтнэ. Мөн хэрэглэгчийн хүсэлтийн дагуу, маш олон сонголттойгоор үйлдвэрлэх боломжтой байдаг нь бас нэг давуу тал юм. Эдгээр боломжит сонголтуудаас дурьдвал оролт гаралтын өргөтгөл, fieldbus сүлжээний адаптеруудын сонголтууд, du/dt шүүлтүүр, ЦСН-н шүүлтүүр, тоормозлох эсэргүүцэл, гал хамгаалагч болон үндсэн таслуур зэрэг болно. Асинхрон хөдөлгүүрүүд, синхрон хөдөлгүүрүүд болон серво хөдөлгүүрүүдтэй холбон ашиглахад ямар нэгэн нэмэлт програм хангамж шаардлагагүй байдаг. Эдгээр давтамж хувиргагч нь өндөр нарийвчлал бүхий удирдлагын платформ, шууд мушгилтын моментын удирдлагын тусламжтайгаар хөдөлгүүрүүдийг задгай эсвэл битүү автомат удирдлагын системээр удирдах боломжтой юм. Төхөөрөмж өөрөө аюулгүй ажиллагааны шаардлага хангасан тул нэмэлт төхөөрөмж шаардлагагүй юм.

Энэхүү давтамж хувиргагч нь IEC 61131-3 стандартад суурилсан програмчлалын орчинд тохиромжтой.

**Нэг удаа сураад, түүнийгээ төрөл бүрийн ашиглалтанд хэрэглэ!**

Эдгээр давтамж хувиргагчууд нь нэгдсэн нэг төрлийн удирдлагын дэлгэц, параметрын цэсны бүтэц, дагалдах хэрэгсэл болон инженерчлэлийн хэрэгсэлтэй байна. Удирдлагын дэлгэц нь нягтаршил сайтай бөгөөд өндөр мэдрэмжтэй тул ажиллахад хялбар байдаг. Мэдээллийг ухаалагаар боловсруулж, хэлбэржүүлэн графикаар харуулах боломжтой ба энэ нь хэрэглэгчид процессоо хянах, хялбар тохируулгын боломж олгодог. Төхөөрөмжийн цэс болон мэдээллүүд нь тухайн хэрэглэгчид тохирсон тусгай нэр томъёо ашиглан өөрчлөх боломжтой байна. USB портоор төхөөрөмжийг компьютертай холбон давтамж хувиргагчийн тохируулгын програмаар түргэн асаалт хийх, ажиллагаанд бэлтгэх, хяналт хийх боломжийг олгодог. Эрчим хүчний зарцуулалтын тооцоолуур нь ашигласан болон хэмнэсэн кВт/цаг, бууруулсан CO<sub>2</sub> болон хэмнэсэн зардлын хэмжээ гэх мэт мэдээллээр хангах ба энэ нь хэрэглэгчийг процессоо хянах, сайжруулах, эрчим хүчийг хэмнэлттэйгээр зарцуулах боломжоор хангадаг байна. Энергийн оновчтой удирдлагын горим нь нэгж гүйдэл дэх хамгийн их мушгилтын момент болон тэжээлийн үүсгүүрээс хэрэглэж буй энергийн бууруулалтыг хангадаг. Мөн уг давтамж хувиргагч нь өөр дээрээ тохируулга, үйлчилгээ хийх боломжит сонголтуудтай байдаг.



3AAUA000094887 REV G EN 18.11.2014 #17306

Техникийн өгөгдөл	
Хүчдэл болон чадлын түвшин	3-фаз, 380 ~ 690 В +10/-10% 45 ~ 2800 кВт
Давтамж	50/60 Гц ±5%
Үндсэн хязгаарлагч	Стандартаар
Хамгаалалтын зэрэг	IP22, IP42, IP54 (UL type 12)
Орчны температур	0 ~ +50 °C, (>40 °C-д гажилттай)
Нийцэмж	CE; EAC/GOST, UL, cUL, CSA, C-Tick
Аюулгүй ажиллагаа (TUV Nord сертификаттай)	Мушгилтын моментыг хянах функц (STO), аюулгүй зогсолт 1 (SS1), яаралтай аюулгүй зогсолт (SSE), хязгаарлагдсан аюулгүй хурд (SLS), аюулгүй тоормозны хяналт (SBC), х/и аюулгүй хурд (SMS), зорилтот бус асалтаас сэргийлэх (POUS)
ЦСН	IEC 61800-3 -ийн дагуу, C3 болон C2 ангилал
Удирдлагын холболтууд	2 аналог оролт, 2 аналог гаралт, термисторын оролтыг агуулсан 6 тоон оролт, 2 тоон оролт, гаралт, 3 релений гаралт, драйв интерлок оролт, драйвуудын холболт (эсвэл Modbus RTU), мушгилтын моментыг хянах функц (STO), 24 В DC гадны тэжээлийн оролт, санах ойн холболт, удирдлагын дэлгэцний USB порт
Удирдлагын болон мэдээлэл дамжуулалтын сонголтууд	
Fieldbus адаптерууд	PROFIBUS DP, DeviceNet™, CANopen, EtherNet/IP™, Modbus TCP/IP, PROFINET IO, EtherCAT®, Modbus RTU, PowerLink, ControlNet
Оролт/гаралтын өргөтгөлүүд	FIO-01: 4 тоон оролт, гаралт, 2 релений гаралт FIO-11: 3 аналог оролт, 1 аналог гаралт, 2 тоон оролт, гаралт FDCO-01, FDCO-02: DDCS холбооны сонголтууд
Гэдрэг холбоо бүхий автомат удирдлагын модуль	TTL пульс тоологч, HTL пульс тоологч, абсолют тоологч, хувиргагч
Компьютерын програм	Drive composer entry Drive composer pro

Дэлгэрэнгүй мэдээллийг АББ-ын төлөөлөгчийн газар болон доорх цахим хаягаар хандан авна уу:

[www.abb.com/drives](http://www.abb.com/drives)  
[www.abb.com/drivespartners](http://www.abb.com/drivespartners)



ACS880 single drives web page